

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн
2025 оны 12 дугаар сарын 04-ны
өдрийн Удирдах зөвлөлийн
хурлаар батлав.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ШИЛДГИЙН ШИЛДГИЙГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭЛ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь “Tourism Awards” арга хэмжээний үед аялал жуулчлалын салбарын оны шилдгийн шилдэг шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох, шагнал олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төрийн албан хаагчид Монгол Улсын цол олгох, төрийн дээд одон медалиар шагнуулахаар нэр дэвшүүлэхэд энэ журам хамаарахгүй.

1.3. Монгол Улсын аялал жуулчлалын салбарт гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд санаачилгатай, үр бүтээлтэй ажиллаж, салбарын хөгжилд хувь нэмэр оруулсан гадаадын иргэнд энэхүү журамд заасан шагналыг олгож болно.

ХОЁР. ШАГНАЛЫН АНГИЛАЛ

2.1. Аялал жуулчлалын салбарын “Оны шилдгийн шилдэг шагнал” нь дараах төрөлтэй байна:

2.1.1. Туризм Авардс

- 2.1.1.1. Оны шилдэг хөрөнгө оруулагч
- 2.1.1.2. Оны шилдэг хамтын ажиллагаа
- 2.1.1.3. Оны шилдэг тогтвортой аяллыг дэмжигч
- 2.1.1.4. Оны шилдэг салбар холбоо – шилжин явах цом

2.1.2. Оны шилдэг өргөмжлөл

- 2.1.2.1. Оны шилдэг тур оператор
- 2.1.2.2. Оны шилдэг хөтөч, тайлбарлагч
- 2.1.2.3. Оны шилдэг жуулчны бааз
- 2.1.2.4. Оны шилдэг зочид буудал
- 2.1.2.5. Оны шилдэг жуулчны тээврийн үйлчилгээ
- 2.1.2.6. Оны шилдэг нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч
- 2.1.2.7. Оны шилдэг зорин очих газар
- 2.1.2.8. Оны шилдэг нийгмийн хариуцлагын ажил
- 2.1.2.9. Оны шилдэг эвент
- 2.1.2.10. Оны онцлох үйл явдал

2.2. Шагналд нэр дэвшигч нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

2.2.1. Хувь хүн бол Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлээгүй байх;

2.2.2. Хуулийн этгээд бол шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр эрүүгийн хариуцлага хүлээгээгүй, үйл ажиллагаа нь түдгэлзээгүй, татан буугдаагүй байх.

2.2.3. Аялал жуулчлалын салбарт 3-аас доошгүй жил ажилласан байх

2.2.4. Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гишүүн байх.

2.3. Шагналд нэр дэвшигч нь шагналын төрлөөс хамаарч дараах тусгайлсан шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.3.1. Оны шилдэг хөрөнгө оруулагчид нэр дэвшигч нь аялал жуулчлалын салбарт хийгдсэн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ хамгийн өндөр байх;

2.3.2. Оны шилдэг хамтын ажиллагаа нь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд, жуулчны тоог нэмэгдүүлэхэд хамгийн өндөр үр бүтээлтэй ажилласан байх

2.3.3 Оны шилдэг тогтвортой аялал жуулчлалыг дэмжигч нь тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан байх

2.3.4 Оны шилдэг салбар холбоо нь

2.3.4.1 Салбарын бодлого, стандарт, зохицуулалтыг сайжруулахад оролцсон байдал

2.3.4.2 Шинэ санаачилга, шинэ үйлчилгээ, шинэ аргачлал нэвтрүүлсэн эсэх

2.3.4.3 Салбарын өсөлт, чанар, хүртээмжид үзүүлсэн бодит нөлөө үзүүлсэн байх ба шилжин явах цомоор шагнана.

2.3.5. Оны шилдэг өргөмжлөлийг гардуулахдаа дараах нэмэлт шаардлагыг харгалзаж үзнэ

2.3.5.1. Үйлчилгээ үзүүлсэн жуулчны тоо

2.3.5.2. Аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах болон өвлийн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ажилласан байдал

2.3.5.3. Жуулчдын тоог нэмэгдүүлэхэд зориулан хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

2.3.5.4. Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлсэн, инновац, шинэлэг байдал хөгжүүлсэн

2.3.5.5. Хүний нөөцийг чадавхжуулах, нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа

2.3.5.6 Оны шилдэг эвент нь олон улсад Монгол Улсыг сурталчилсан байдал болон хүлээн авсан жуулчны тоо, олон улсад түгээсэн контентын тоогоор хамгийн өндөр байх

2.3.5.7 Оны шилдэг хөтөч, тайлбарлагчийг хөтөч тайлбарлагчийн холбооны шагнал тодорхойлох журмын дагуу шалгаруулна.

2.3.5.8. Шалгаруулах комиссоос тухайн шагналын онцлогт тулгуурлан нэмэлт шаардлага оруулж болно.

ГУРАВ. ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ

3.1. Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх) нь аялал жуулчлалын салбарын “Туризм авардс”, “Оны шилдэг өргөмжлөл”-д хэрхэн нэрээ дэвшүүлэх, шагналыг хэзээ, хэрхэн олгох болон холбогдох бусад мэдээллийг шагналыг олгохоос 10-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

3.2. Аялал жуулчлалын салбарын “Туризм авардс”, “Оны шилдэг өргөмжлөл”-өөр шагнуулах саналыг дараах этгээд гаргана:

3.2.1. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

3.2.2. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн, Гишүүн, Гүйцэтгэх захирал, Салбар холбоод;

3.2.3. энэхүү журмын 2.2-д заасан чиглэлээр аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаагаа явуулдаг иргэн, хуулийн этгээд.

3.3. Энэхүү журмын 3.2-т заасан санал гаргаж байгаа этгээд нь шагналд нэр дэвшигч эрхэлсэн ажилдаа ямар санал санаачилга, ололт амжилт, бүтээл гаргасан, түүнийг хэрэгжүүлснээр улс, эх орны болон аялал жуулчлалын салбар, аялал жуулчлалын үйл ажиллагааны хөгжилд ямар ашиг тус, ахиц гарсныг баримтаар дурдан тусгаж, гаргасан амжилтад тохирох шагналын төрөл, нэрийг тодорхой заасан саналаа бичиж, баталгаажуулсан байна.

3.4. Шагналд шагнуулахаар нэр дэвшүүлж буй этгээд нь дараах материалыг ажлын албанд хүргүүлнэ:

3.4.1. энэхүү журмын 2.1-д заасан шагналд нэр дэвших талаарх албан бичиг эсхүл хүсэлт;

3.4.2. энэхүү журмын 2.2, 2.3-т заасан шаардлагыг хангасан талаарх мэдээлэл, танилцуулга, гэрэл зураг, бичлэг, холбогдох баримт

3.4.3. онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт, бичиг, шийдвэрийн хуулбар.

3.5. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн Ерөнхийлөгч, шалгаруулалтын ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн энэхүү журмын 2.1-д заасан шилдгийн шилдэг шагналд гарын үсэг зурж баталгаажуулна.

3.6. Шагналыг “Tourism awards” арга хэмжээний үед гардуулна.

3.7. Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг ажлын алба бие даан шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. ШАЛГАРУУЛАЛТ

4. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн Удирдах зөвлөлөөс томилогдсон шалгаруулах комисс энэхүү журмын 3.3, 3.4-т заасны дагуу ирүүлсэн саналыг хуралдаанаар хэлэлцэж, нэр дэвшигчийг холбогдох ангиллын аялал жуулчлалын салбарын шилдгийн шилдгээр шагнуулах болзол, шаардлагыг хангасан гэж үзвэл шагнал олгуулах шийдвэр гаргана.

4.1. Шалгаруулах комисс нь АЖМХ-ны чиг үүргийн хорооны дарга нар, гүйцэтгэх захирлаас бүрдэнэ.

4.2. Шалгаруулах комиссоос тухайн номинацийг шалгаруулахдаа нэр дэвшигчдээс шилдэг гурван нэр дэвшигчийг (шорт лист) тодруулан нийтэд зарлана.

4.4 Шалгаруулах комиссоос тухайн номинацид шалгарах байгууллага, хувь хүн байхгүй тохиолдолд шалгаруулахгүй байж болно.

---oOo--